



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАЯН-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 28 өдөр

Дугаар A/170

Баян-Өндөр сум

Уяачдад цол олгох тухай

Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5, 8.7 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Сумын алдарт уяач болох болзол хангасан нэр бүхий уяачдыг хавсралтаар баталж сумын алдарт уяач цол олгосугай.
2. Хавсралтаар батлагдсан уяачдын цолны тодорхойлолт холбогдох баримт бичгийг бүрдүүлж уяачдын холбоонд хүргүүлэхийг уяачдын холбооны дарга (Б.Батбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЧУЛУУНШАГАЙ

Засаг даргын 20<sup>22</sup> оны 12<sup>р</sup> сарын  
29-ны өдрийн 41/20 захирамжийн хавсралт



## ЦОЛ ОЛГОХ УЯАЧДЫН НЭРС

1. Дашзэвэг Анхбаяр
2. Алтанзул Бадрахзул
3. Доржпалам Мягмар
4. Ихзориг Хатансайхан
5. Ханхай Бархас
6. Пэлжээ Санжаасүрэн
7. Базаррагчаа Мөнхбат
8. Чинбишрэл Саруулбуян
9. Баасанжав Ганбаатар
10. Наянтай Нямхүү



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАЯН-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 30 өдөр

Дугаар А/171

Баян-Өндөр сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Агаарын бохирдлын эх үүсвэрийн Улсын нэгдсэн тоо бүртгэлийг суманд хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Нямсүрэн (Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга: Д. Рагчаа (Байгаль орчны хяналтын Улсын байцаагч)

Гишүүд: Н.Түвшинжаргал (Газрын даамал)

Б.Өлзий-Орших (Цаг уурын эрхлэгч)

Багийн Засаг дарга нар

2. Ажлын хэсэгт хяналт тавьж удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Нямсүрэн)-д даалгасугай

ЗАСАГ ДАРГА



С.ЧУЛУУНШАГАЙ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАЯН-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 30 өдөр

Дугаар А/172

Баян-Өндөр сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өвс тэжээл хүлээж авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Нямсүрэн (Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга: Д. Сонинбаяр (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: Г.Бадьмэд (Бэлчээр, газар тариалан хариуцсан

мэргэжитэн)

Н.Дэлгэрбат (Засаг даргын Тамгын газрын нярав)

Багийн Засаг дарга нар

2. Ажлын хэсэгт хяналт тавьж удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Нямсүрэн)-д даалгасугай

ЗАСАГ ДАРГА



С.ЧУЛУУНШАГАЙ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАЯН-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 6/01

Баян-Өндөр сум

Хариуцлага тооцох тухай

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Шилэн дансны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 2021 онд өгсөн санхүүгийн хяналт шалгалтын Улсын байцаагчийн 3 удаагийн албан шаардлагыг хангалтгүй биелүүлсэн эрүүл мэндийн төвийн дарга Б.Дашдэлгэрт нийтэд нээлттэй сануулах арга хэмжээг тооцсугай.

2. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчилд дүгнэлт хийж цаашид анхаарч ажиллахыг эрүүл мэндийн төвийн дарга, нягтлан бодогч нарт үүрэг болгосугай.

3. Уг захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг санхүү албаны дарга (Ю.Дуламхорлоо)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЧУЛУУНШАГАЙ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАЯН-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 12 өдөр

Дугаар Б/02

Баян-Өндөр сум

Хариуцлага тооцох тухай

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөдөлмөрийн гэрээнд заасан ноцтой зөрчилд тооцогдох ажил олгогчийн ажил хэргийн нэр хүндийг гутаасан үндэслэлээр Соёлын төвийн эрхлэгч (Б.Хишигдэлгэр)-д нийтэд нээлттэй сануулах арга хэмжээг тооцсугай.

2. Цаашид хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу зөрчил гаргахгүй байхад анхаарч ажиллахыг Соёлын төвийн эрхлэгч (Б.Хишигдэлгэр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЧУЛУУНШАГАЙ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАЯН-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 6/03

Баян-Өндөр сум

Сахилгын арга хэмжээ тооцох  
тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 65 дугаар зүйлийн 65.1.3, 65.3.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.3, 123.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өгсөн үүрэг даалгавар хангалтгүй биелүүлсэн, хугацаатай мэдээ тайлан хоцроосон 1 дүгээр багийн Засаг дарга (А.Ганбаатар), 3 дугаар багийн Засаг дарга (Ш.Гүрдорж), 4 дүгээр багийн Засаг дарга (Н.Гэндэнжамц), 5 дугаар багийн Засаг дарга (Э.Жанлав) нарт нийтэд нээлттэй сануулах арга хэмжээ тооцсугай.

2. Дээрх зөрчлийг гаргасан 2 дугаар багийн Засаг дарга Ц.Төрбат нь урьд сануулах арга хэмжээ авагдсан тул үндсэн цалинг 20 хувиар нэг сар хасах сахилгын шийтгэл оногдуулсугай.

3. Цаашид хуульд заасан үүргээ гүйцэтгэж, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж зөрчил гаргахгүй байхад анхаарч ажиллахыг Багийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Ц.Төрбатын цалинг нэг сараар 20 хувь хасаж олгохыг нягтлан бодогч (Ц.Долгормаа)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.ЧУЛУУНШАГАЙ